



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 11836

Арвайхээр

Г Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 336 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-ын 8.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссоос аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 7 суманд эрсдэлийн түвшин их, 12 суманд дунд эрсдэлтэй гарсан байх тул зудын элсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр аймаг, сумын өвс тэжээлийн нөөцэд авсан 3860 боодол өвсний үлдэгдэл санхүүжилт 18,480,000 (арван найман сая дөрвөн зуун наян мянга) төгрөгийг Ховд аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011101363